



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/223

Булган сум

**“Амар тайван Булган” хөтөлбөрийн зардлаас
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт хөтөлбөр батлах тухай", аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн "Хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардлын хуваарийг шинэчлэн батлах тухай" А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 6,600,000 (зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг “Амар тайван Булган” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. “Амар тайван Булган” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх ажил, хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/22 дугаар захирамжийн хавсралт

“АМАР ТАЙВАН БУЛГАН” ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛААГ САНХҮҮЖҮҮЛЭХ
АЖИЛ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгө зарцуулах зориулалт	Зохион байгуулах нэгж	Хэмжээ	Мөнгөн дүн (төгрөг)
1	2	3	4	5
1	2024,2025 оны байдлаар гэмт хэрэг давтамжтай өссөн 6 суманд зохион байгуулах “Орлоготой өрх” үйл ажиллагааны зардал	Хууль эрх зүйн хэлтэс	6 суманд зохион байгуулах зардал	1,784,430
2	Архивын салбар үүсч хөгжсөний түүхт 98 жилийн ойг угтсан архив албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудын дунд зохион байгуулах “АХА” тэмцээний зардал	Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын тасаг	“АХА” тэмцээний оролцогч нарт олгох шагналын зардал	1,000,000
3	Бүгд Найрамдах Монгол Ард Улс байгуулснаа тунхагласны баярын өдрийг угтан Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулах “Бид ирээдүйн хуульчид” дэвжээ тэмцээний зардал	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Аймгийн Засаг даргын тамгын газар	“Бид ирээдүйн хуульчид” дэвжээ тэмцээнд шалгарсан багийн шагналын зардал	2,250,000
4	Хишиг-Өндөр сумын ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн сурагчдыг оролцуулсан “Хариуцлагатай сонгогч” сургалтын зардал	Хууль, эрх зүйн хэлтэс	Суралцагчдын сургалтын зардал	560,000
5	Тэшиг сум дахь Хилийн цэргийн 0286 дугаар ангийн алба хаагчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг оролцуулсан хууль таниулах, сурталчлах “Хуулийн гэрэл” буухиа тэмцээний зардал	Хилийн цэргийн 0286 дугаар анги	“Хуулийн гэрэл” буухиа тэмцээнд шалгарсан багийн шагналын зардал	1,000,000
Нийт				6,600,000